

НЭГДҮГЭЭР БАЙР:

*Чингэлтэй дүүргийн 19 дүгээр цэцэрлэгийн хөгжмийн багш
Л.Ариунжаргал*



Миний бахархал миний шавь

Ажлын нэг өдөр унтлагын цагаар хүүхэд шиг өөрийн эрхгүй нойр хүрээд ширээгээ дэрлэн дуг хийлээ.

Зүүдэлж байна. Мэдрэгдээд байна. Харагдаад байна. Бүр яасан гээч

Хараад л арааны шүлс асгармаар

Хачин гоё байшин би зүүдэллээ

Жигнэмэгэн хана, шокладан ширээ

Мөсөн чихэр сандал, жимсэн тоглоом

Хазчихмаар, идчихмээр

Хачин гоё цэцэрлэг би зүүдэллээ.

Энэ миний бахархал .миний шавь нарын өргөө

Дуутай насныхаа түүхийг өлгийдсөн

Дурсамж дүүрэн хөөрхөн миний шавь

Дэгдээхий насныхаа жигүүрээр шулганасан

Дэндүү хөгжилтэй миний шавь миний бахархал

Би БАГШ хэмээх эрхэм нэрийг хүртэж амьдралынхаа замыг эхэлсэн. Мэдээж тэр үед чадахаасаа илүү чадахгүй загнуулж, онохоосоо илүү алдаж явсан ч эрдэм оюуныг тэтгэгч Чингэлтэй хайрханаараа овоглон, С.Янжмаагийн нэрэмжит хөгжмийн угшилтай, туршлагатай Оюунчимэг багшаараа удирдуулсан 19-р цэцэрлэгт олон сайхан авъяаслаг багш, шавь нарынхаа дунд урам зоригтой баяр баясгалантай ажиллаж байна. Монголын ирээдүй болсон бага насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол тэр тусмаа гоо зүй. Урлаг уран сайхны хүмүүжил хөгжим, дуу, бүжгээр сургаж, хөгжүүлж, хүмүүжүүлэх нь

миний үүрэг юм. Багш хүн бүр сайхан хүсэл мөрөөдлөөр дүүрэн байдаг. Хүсэл мөрөөдөл биднийг цэнэглэдэг. Хүсэл мөрөөдөл бидний ирээдүйг өдөр бүр сайхан байх болгоно гэдэгт итгүүлдэг. Хүсэл мөрөөдөл дууссан газар хүн өөрөө дуусдаг. Иймд бодит байдлыг ухамсарлаж хүүхэд бүр шавь болгоноо хөгжүүлэх нь миний бахархал. Иймээс багш би шавь нартайгаа илүү ажиллаж, сургаж, хүмүүжүүлж хөгжүүлэх боломжийг байнга эрэл хийж өөрөө хөгжиж шавиараа бахархах нь чухал гэдгийг олж харсан. Сэтгэлийн ойр дотно холбоо, таатай уур амьсгал бий болгон хүүхдэд ойр байснаар тэд ямар сонирхол, бодолтой байгаа, яаж тэдэнд нөлөөлж болох, хэрхэн тэдний үйлийг идэвхжүүлэх, сэдэл бий болгохоо олж мэддэг.

Ингээд л би шавь нартайгаа ажиллаж эхэлдэг

Ингээд л миний онгод тэднийг хараад хөглөгддөг

Тэгээд л тэд баяр баясгалантай инээд хөөрөөр цалгилдаг

Тэгээд л тэдний хүсэл мөрөөдөл биелэгддэг

Шавь нараа хараад миний сэтгэл хайрар бялхаж өөртөө бахархаж тэдэндээ баяр хүргэж, үнсэж, тэврэх, өхөөрдөх магтах, сайшаах, урам өгөх, баярлан уйлах гээд заримдаа юу болоод өнгөрөв өө гэгч болох юм даа.

Энэ бүхэн “Миний бахархал, миний шавь” нар,,,

“Хөгжим маш их гайхамшигтай бөгөөд өвөрмөц онцгой хэл” Д.Шостакович




ХОЁРДУГААР БАЙР : ӨМӨЗО-ны Шулуун хөх хошууны Өүлэн хүүхдийн цэцэрлэгийн Багш: Соргог

Миний шавь нар-миний бахархал

Сайн байцгаана уу? Та бүхний өнөөдрийн амгалан мэндийг өргөн дэвшүүлье. Намайг Соргог гэдэг. Өвөр Монгол Өөртөө Засах орны Шилийн гол аймгийн Шулуу хөх хошууны Өүлэн хүүхдийн цэцэрлэгийн багш. Энд би “Миний шавь миний бахархал” сэдвээр уран илтгэл хийх болсондоо маш баяртай байна. Ер нь хүний амьдралын урт аянд олон багштай учран золгож барахгүй, чадахгүй орчлонг багшийн сайнаар туулдаг учиртай. Харин тэгэхэд хүн болгон шавь дагуулж сурсанаа уламжилж явдаггүй нь ч учиртай юм. Өөрөө шавь дагуулсан, өрөөлд багш нэрээ дуудуулсан хүмүүсийн хайр хариуцлага, үүрэг тийм хялбархан биш гэж би хувьдаа боддог. Би бол нэгэн цэцэрлэгийн багш хэдийгээр бичигтэй өдөржин ноцолдож билэг ухааны сориогоор сурагчдаа хүмүүжүүлдэггүй ч гэсэн аав ээжээсээ арай гэж салан, алхаа нь дөнгөж тэнцэж байгаа бүүвэй нарыг хоёр нарны хооронд идүүлж, уулгаж, унтуулж амруулахаас эхэлж инээж уйлахийг нь хүртэл арагдаж саатуулан, байгаа хэмжээнд нь үүрч чадах билгийн сорыг зааж таниулах гэж бидний ажил мундахгүй юм. Цэцэрлэгийн сурган хүмүүжил буюу нялхсын хүмүүжил бол бүхий л сурган хүмүүжлийн дундах хамгийн чухал хүндэтгэн үзэх ёстой ажил гэж би хувьдаа боддог. 3-6 насны хүүхдийн хүмүүжил тэр хүүхдийн насан туршийн хүмүүжлийн үндэс болж тогтнодог. Иймээс цэцэрлэгийн багш болсон бидний үүрэг маш хүнд Чив хэмээн хөөрхөн шувуудыг хүмүүжүүлэх үүрэг нэн хүнд байдаг. Би өөрөө цэцэрлэгийн багш болсон гараагаа аваад 5 жил гаруй болж байна. Олон сайхан шавьтай хүн шүү дээ. Миний шавиуд маш сэргэлэн маш мундаг шүү. Ажилдаа дарагдаад яаруухан байхад дэрэгдээс шулганаж багш та түр сууж амраач гэдэг. Ангаж цангаж ус цай уухын чөлөөгүй мунгинаж байхад аяга цай бариад өөдөөс зогсдог аргагүй тусч жаалууд даа. Таниулж зааж өгсөнийг минь дэв хийтэл эзэмшиж намайг баярлуулдаг. Тэгээд бас зогсохгүй цэцэрлэгийн гол гол уралдаанаар манай жаалууд манлайлж хөтлөгч, бяцхан алиалагч болон багшдаа дэндүү сайхан баяр бахдалыг олгож байдаг. Үүнээс гадна эх хэлний бахархал гэж надад бас нэг том бахархал бии. Харь хэлний орчинд нөлөөлөгдөж ажил амьдралын дунд ч хэрэгжүүлдэг болсон та бид жаалуудын бодол сэтгэлийг анхаарч ойлгож үзсэн үү. Манай өвөр монголчууд хятад хэлийг зөндөө хольж ярих гээд байдаг шигээ Монголд ч орос хэл холигдож байдаг байх. Багш болон хүмүүс мэдээж хамгийн дээд баримжаагаар өөрийгөө шаардаж эх хэлний хүмүүжлийг шавь нартаа зөв сайн уламжлах ёстой байдаг. Гэтэл зарим үед амьдралийн хэлээр анзааралгүйгээр ямар нэгэн санаандгүй зүйлийг хятадаар хэлчихэд шавь нарууд минь харин сонсонгуутаа багшдаа юу гэдэг үгийг Хятадаар хэлчихлээ тэр чинь Монголоор ингэж хэлдэг гээд залруулаад өгдөг. Энэ нь миний шавь нараараа бахархсан омогшил болдог. Эргээд өөрийгөө зэмлэх, сэрэмжлэх дохио болдог. Миний хөөрхөн шавиуд ч багшаараа бахархдаг шүү. Миний багш сайн багш ухаантай багш гэж аав ээжийнхээ дэргэд үргэлж ярьдаг. Цэцэрлэгээ төгсөөд бага сургуульд явсан ч үргэлж багшаа зорьж ирээд сайн байна уу таныгаа саначихлаа гээд

хүзүүнээс минь тэврээд үнсдэг. Аав ээж нь үргэлж бид нартай харилцан та нарын хайр хүмүүжлээр хүүхдүүд чинь олон сайхан уралдаанаар өөрийгөө сорьж өрөөлөөс оройлж гялалзан явж байна. Тандаа баярласан шүү гэдэг энэ сайхан үгийг сонсоод би өөрийн эрхгүй сэтгэл хөдөлж тэр үеийн минь хүч хөдөлмөр амжилт олсон байна гэж бодол төрөгдлөө. Хөөрхөн шавиудаараа ч бахархлаа. Цэцэрлэгчийг эрвээхэй цуглуулсан бал, цогшихыг хөгжөөсөн дөл гэж хэлдэг. Уг нь би энэ үгний утгыг бүрэн ойлгодоггүй байсан. Одоо бодоход маш тодорхой болсон юм. Манай цэцэрлэгчид бол тэр дэгжин эрвээхэй нарын хурж амтлах амтат бал, цогшин улайсан байгаа галыг хөгжөөх дөл нь болдог. Бид бал болсоны учир амтаа улам чихэрлэг шимтэй нэрж, бид дөл болсны учир очоо улам бадраан хөгжөөх ёстой билээ. Манай Монголын үр сад маргашгүй бидний мөнхийн бахархал байх учиртай. За миний уран илтгэл энд хүрээд өндөрлөж байна. *Таалан болгоосон та бүхэндээ баярлалаа. Ажлын өндөр амжилт аливаа бүхний сайн сайхныг хүсье.*



ГУРАВДУГААР БАЙР : ӨМӨЗО-ны Шулуун хөх хошууны Монгол үндэсний хүүхдийн цэцэрлэгийн Багш:М.Хасчимэ

МИНИЙ ШАВЬ-МИНИЙ БАХАРХАЛ

Хүн эхээс төрж, эх дэлхийд унасан цагаас тэдний анхны багш нь аав, ээж нь байдаг бол цэцэрлэгийн хаалгыг алхаж орсон анхны өдрөөс эхлэн тэдний багш нь бид л болох ёстой. Би цэцэрлэгт анх ажиллахад маш хэцүү байсан. Энэ мэргэжлийг эзэмшихэд чухам юу хийдэг, ямар байдаг гэдгийг ердөө мэддэггүй байсан. Зөвхөн л багш гэдэг үг гоё санагдаж, хүмүүсийн саналаар энэ мэргэжлийг сонгосон. Анх хүүхдүүдтэй учрахад “Нэг өдрийг яаж өнгөрөөнө” гэж санаа зовдог байлаа. Дотны хүмүүс надад “Чи гоё ажил хийдэг юм байна. Багш гэдэг чинь хүмүүсийн оюун ухааны нар нь юм шүү” гэж захидаг. Би дотроо юу нь гоё байдаг юм бэ? бөөн ажил гэж бодсон. Гэхдээ хүүхдүүдтэй байсан мөч бүхэн утга агуулгатай, мартагдашгүй болно гэдгийг би мэдээ ч үгүй байсан. Миний хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлсэн дурсгалтай мөч олон байсан.

Анхны жилдээ ажиллаж байхад нөхөртэйгөө ам зөрөөд санаа сэтгэл тайван бус уур уцаартай цэцэрлэгийн хаалгыг алхаж орлоо. Багш хүн өөрийнхөө буруу сэтгэлгээг ажил дээрээ авч ордоггүйг би мэдлээ ч гэсэн, өөрийнхөө уур уцаарыг дарж чаддаггүй гэдгийг ойлгосон. Намайг ангид ороход хүүхдүүд орилолдож, шуугилдан гүйлдээд бөөн шуугиан болж байлаа. Миний уур уцаар бүр ч хөдөлж тэр дороо хүүхдүүдээ загналаа. Хүүхдүүд миний дуунаар чимээгүй боллоо, анги дотор амьсгалахаас өөр ямар ч дуу алга, гэвч миний уур тайтгараагүй, яг энэ үед нэг бяцхан хүү, дэргэд ирээд “Багшаа та уурлахаараа гоё харагддаггүй юм байна шүү” гэж хэллээ. Тэр үгэнд нь миний сэтгэл тайтгарсан. Яагаад тэгж тайтгарсныг би одоо ч гэсэн бодож олоогүй, хүүгийн хөөрхөн аашинд тайтгарсан байхдаа.

Би ажлын шаардлагаар өөр аймаг руу суралцахаар явлаа. Намайг явсны хэдэн хоногийн дараа хамт ажилладаг багш над руу утасдлаа. Би маш их гайхаж “Яахаараа над руу утсаар ярьдаг юм бол” гэж бодон утсаа авахад цаанаас нь хөөрхөн хүүгийн дуу гарлаа. “Багшаа та хаана явсан юм бэ?, би таныг маш их санаж байна” гэж хэлэхэд миний сэтгэл тэрхэн мөчид уярлаа. Хэдийгээр би тэр үед өөрөө хүүхэдгүй байлаа ч гэсэн тэр дуу надад хичнээн их дотно, хичнээн халуунсаг байсныг яана. Энэ бүхнийг бодохоос хүүхэд гэж цайлган, хичнээн хөөрхөн байдгийг би анзаарлаа. Би чинь тэднийхээ, оюун ухааны нар нь юм шүү гэж бодлоо. Хамт байсан мөч бүхэн тийм хосмхон гэдгийг би сүүлд нь ухаарсандаа. Одоо би өөрөө ч гэсэн үртэй болсон. Хүүхдүүд минь уралдаан тэмцээнд уралдаан тэмцээнд оролцоход тэднийхээ өмнөөс илүү зовж, сандарч, шагнал авахад баярлан догдолж, яг л миний хүү шагнал авсан юм шиг надад бодогддог. *Хүүхдүүд минь, миний бахархал баясал юм даа.*